

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/1/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг, Сайншанд сум

2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг:

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг:

Аудитор: Г.Энхтөр.....

Утас: 96441690 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	19

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.11 № 1-6/313а
танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Ц.НАРАНЗУЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

444190320

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь дор дурдсан үндэслэлээр төсөвт байгууллагад хамаарч байхад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан УСНББОУ-ын стандарт, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 тоот тушаалаар баталсан төсвийн ангилал, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 216 тоот тушаалаар баталсан журам, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 тоот тушаалаар баталсан зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаагүй байна. Үүнд:

1. 2006 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот шийдвэрээр бүртгүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын хариуцлагын хэлбэрийг төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж заасан.
2. Дорноговь аймгийн Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/72 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан "Нийтлэг үйлчилгээний газрын дүрэм"-ийн 1.1-д "Аймгийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газар нь /цаашид "Газар" гэнэ/ аймгийн Засаг дарга түүний Тамгын газар болон төсвөөс санхүүждэг бусад байгууллага /цаашид "үйлчлүүлэгч" гэнэ/-ын хэвийн үйл ажиллагааг хангах нийтлэг үйлчилгээний талаар тогтоосон нэгдсэн бодлогыг хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий нутгийн захиргааны хэрэгжүүлэгч "Орон нутгийн төсөвт албан газар" мөн" гэж тодорхойлсон.
3. Тус дүрмийн 1.3-д "аймгийн Засаг дарга тус газрын бүтэц, орон тоо, дүрмийг батална" гэж заасан.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Нийтлэг үйлчилгээний газрын дарга Ц.Наранзулд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 1-нээс 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь хэрэглэгчдэд олон улсын чанар, стандартын түвшинд хүрсэн нийтлэг үйлчилгээ үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

2006 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот үүсгэн байгуулах шийдвэрээр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн баримт бичигт Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төсөвт байгууллагуудад эд хогшил, бараа материал захиалгаар нийлүүлж үйлчлэх
- Хэвлэх цех
- Тээвэр үйлчилгээ
- Харуул хамгаалалтын үйл ажиллагаа
- Цэвэрлэгээний үйл ажиллагаа эрхлэх

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого холбогдох хууль, журамд нийцээгүй буюу УСНББОУС-д нийцэхгүй байна.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Leader” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 22 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлэх тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Нийтлэг үйлчилгээний газар 2018 оны Нийт зардал 1,680,043.29 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 3,360.09 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнг харгалзан үзэж хамгийн бага хувиар тооцох нь оновчтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 10 чиглэлээр аудитын 21 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 15 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	14	9,511,618.30	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	4,924,163.20	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		15	14,435,781.50	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

2006 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот шийдвэрээр бүртгүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын хариуцлагын хэлбэрийг төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж заасан бөгөөд Аймгийн засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/72 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан "Нийтлэг үйлчилгээний газрын дүрэм"-ийн 1.1-д " ... орон нутгийн төсөвт албан газар мөн" гэж тодорхойлсон байна. Гэтэл тус байгууллага Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2015 оны 7 тоот, 2017 оны 216 тоот, 2006 оны 388 тоот тушаалуудаар баталсан заавар, журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан, төсвийн тайлан гаргаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 7 тоот, 2017 оны 2016 тоот, 2006 оны 388 тоот тушаалуудаар баталсан заавар, журмыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар байгууллагын хариуцлагын хэлбэрийг өөрчилсөн эсэх, өөрчлөөгүй бол холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үндэслэн нягтлан бодох

бүртгэлийг хөтөлсөн эсэх, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа програм хангамжийг шинэчилсэн эсэх асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр 92,710.2 мянган төгрөгийн, Аймгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу 354,485.2 мянган төгрөгийн төсөв тус тус батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Ажил гүйцэтгэх гэрээгээр гарсан төсвийн зардлын нийт гүйцэтгэл 354,485.5 мянган төгрөг буюу 100 хувьтай, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн төсвийн зардлын нийт гүйцэтгэл 138,176.5 мянган төгрөг буюу 148.6 хувьтай байгаа нь төлөвлөгөөнөөс давсан орлогыг үйл ажиллагаандаа зарцуулснаас шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Нийтлэг үйлчилгээний газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл, үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр гаргасан байна.
2. Жолооч нарын шатахууны үлдэгдэлд тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулдаггүй байна.
3. 2018 оны 12 дугаар 31-ний өдрийн байдлаар нийт 2,064,586.89 төгрөгийн авлагатай, 11,127,611.11 төгрөгийн өглөгтэй байна.
4. Хууль тогтоомжийн дагуу олгож байгаа ХЧТА-н тэтгэмжээс ХХОАТ гэж 10%-г суутган дутуу олгосон байна. Тухайлбал 4 дүгээр сарын 27-нд Б.Сарангэрэлд 9,038.9 төгрөг, 6 дугаар сарын 20-нд Ц.Наранзулд 19,579.6 төгрөг, 10 дугаар сарын 11-нд Б.Ууганбаярт 7,032. төгрөг, А.Мөнхцэцэгт 6,360.0 төгрөг, 12 дугаар сарын 31-нд Б.Бямбаад 10,450.1 төгрөг, 7 дугаар сарын 24-нд Д.Чулуунбатад 8,105.2 төгрөг тус тус дутуу олгосон байна.
5. Хамтын гэрээг хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлээгүй, байгууллагын дотоод журам, хамтын гэрээнд цалинтай чөлөө олгох заалт байгаа боловч цалинг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна.
6. Ээлжийн ажилчдын графикийг сарын эхэнд баталж мөрддөггүй, ээлжийн ажилчдын илүү цагийн хэрхэн шийдвэрлэсэн нь тодорхойгүй, ажилтны ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг зааврын дагуу хөтөлдөггүйгээс ямар хугацаанд хамаарах ажлын жилийн ээлжийн амралтыг олгосон нь тодорхойгүй байна.
7. Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, кодчиллыг Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 тоот тушаалаар баталсан төсвийн ангилалд нийцүүлэн гаргаагүй, дансдын ерөнхий журнал Сангийн сайдын 2018 оны 5

- дугаар сарын 8-ны өдрийн 100 тоот тушаалаар баталсан зааврын дагуу хөтлөгдөөгүй байна.
8. Эрх бүхий албан тушаалтнаар 2018 оны төсөв, төсвийн хуваарийг батлуулаагүй, бусад зардалд 1,386,684,472.06 төгрөг зарцуулсан байна.
 9. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 388 тоот тушаалаар баталсан маягт, зааврын дагуу тайлагнаагүй байна.
 10. 2018 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр Аймгийн ЗДТГ-тай байгуулсан 01 тоот гэрээний 1.1-д гүйцэтгэх ажил үйлчилгээг хавсралтаар гаргахаар заасан боловч гэрээний хавсралт байхгүй 353,155,000.0 төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулсан байна
 11. Амрах өрөөний орлогын тасалбар хэдэн ширхэг үлдэгдэлтэй байсан хэд нэмэгдэж хэд хасагдсан, тайлан тасалбар болгосон хугацаанд хэд үлдсэн талаарх тайлан тооцоо байхгүй баримтын дугаар давхарддаг байна. Тухайлбал 77 тоот баримтаар 2018.11.03-2018.11.04-нд хоёр хүн 35000 төгрөг төлсөн гэтэл мөн 77 тоот баримтаар 2018.12.03-2018.12.04-нд нэг хүн 15000 төгрөгийн тооцоо хийсэн байна
 12. 2018 оны жилийн эцсийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй байна. 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/43 тоот тушаалаар тооллогын комисс томилон тооллого хийсэн боловч комисс 9 дүгээр сарын үлдэгдлээр 11 дүгээр сарын 20-ноос 22-ны өдрийн хугацаанд тооллого хийсэн, тооллогоор дутагдсан 9,000,000.0 төгрөгийн асуудлыг одоо болтол шийдвэрлээгүй байна.
 13. Тус байгууллага нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Leader" програмыг ашиглаж байгаа бөгөөд энэхүү програм тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэл, үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.
 14. Мөнгөн хөрөнгө зарцуулах эрх олгох "зөвшөөрлийн хуудас"-ны маягт гаргаж хаана, хэнд, юуны төлбөр төлөх тухай гүйлгээний утга, мөнгөн дүн, он, сар, өдрийг тэмдэглэж Аймгийн ЗДТГ-ын тамга дарж дарга Г.Эрдэнэцэцэг гарын үсэг зурсан байгаа боловч анхан шатны маягтыг эрх бүхий удирдах дээд байгууллагаар батлуулаагүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Жолооч нарын шатахууны үлдэгдэлд тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулдаггүй байна.

Энэ нь бодитой оршин байх ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Бараа материалын тооллого тооцоо буруу хийгдсэн байх, үлдэгдэл тохирохгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл, үнийн дүнгээр тайлагнаагүй нийт дүнгээр гаргасан байна.

Энэ нь эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргадаггүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан зааврыг судалж мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

